

## **Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол**

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тавиндолдугаар чуулганы 2002 оны арван хоёрдугаар сарын 18-ны өдрийн A/Res/57/199 дүгээр тогтоолоор баталсан.

Протоколд НҮБ-ын Нью-Йорк дахь Төв байранд 2003 оны хоёрдугаар сарын 4-нөөс (Протоколын эх бичвэрийг үйлдсэн огноо) эхлэн гарын үсэг зурах, соёрхон батлах, нэгдэн ороход нээлттэй.

### **ОРШИЛ**

Энэхүү Протоколд оролцогч улсууд,

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх нь хүний эрхийг ноцтой зөрчих бөгөөд хориглох ёстой гэдгийг дахин нотолж,

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц (цаашид "Конвенц" гэж нэрлэнэ)-ийн зорилгод хүрэхэд болон эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг арга хэмжээ цаашид авах шаардлагатай гэдэгт итгэл төгс байж,

Конвенцийн 2, 6 дугаар зүйл нь оролцогч улс бүрт шүүн таслах харъяалалдаа байгаа аливаа нутаг дэвсгэртээ эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйл ажиллагааг зогсоох талаар үр дүнтэй арга хэмжээ авахыг үүрэг болгосныг дахин нотолж,

Эдгээр зүйлийг хэрэгжүүлэх нь оролцогч улсын үндсэн үүрэг болохыг болон эрх чөлөөгөө хасуулсан этгээдийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх, тэдгээрийн хүний эрхийг сахих нь бүх нийтийн үүрэг бөгөөд олон улсын байгууллага үндэсний арга хэмжээг бэхжүүлдэг гэдгийг хүлээн зөвшөөрч,

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс үр дүнтэйгээр урьдчилан сэргийлэхэд боловсролыг дээшлүүлэх болон хууль тогтоох, захиргааны болон шүүхийн буюу бусад арга хэмжээг хослуулан авах шаардлагатайг эргэн санаж,

Хүний эрхийн Дэлхийн Бага хурлаас эрүү шүүлтийг устгах арга хэмжээ, юуны түрүүнд түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэх ёстой гэж шийдвэртэй мэдэгдсэн болон Конвенцийн хорих байрыг тогтмол эргэж байх хамгаалалтын тогтолцоог бий болгох зорилготой нэмэлт протоколыг батлахыг уриалсныг эргэн санаж,

Эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалахын тулд хорих байранд нь тогтмол эргэх замаар шүүхийн бус арга хэмжээг илүү эрчимжүүлж болно гэдэгт итгэл төгс байж

Дараах  
НЭГДҮГЭЭР

зүйлийн

талаар

хэлэлцэн

тохиролцов:  
ХЭСЭГ

## НИЙТЛЭГ ЗАРЧИМ

### 1 дүгээр зүйл

Энэхүү протоколын зорилго нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэхийн тулд олон улсын болон үндэсний хараат бус байгууллагаас эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг саатуулагдаж байгаа байранд нь тогтмол эргэж байх тогтолцоог бий болгоход оршино.

### 2 дугаар зүйл

1. Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны дэргэд энэхүү протоколын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс Урьдчилан сэргийлэх дэд хороо (цаашид "Урьдчилан сэргийлэх дэд хороо" гэнэ)-г үүгээр байгуулж байна.

2. Урьдчилан сэргийлэх дэд хороо ажлаа НҮБ-ын Дүрмийн хүрээнд явуулж, түүний зорилго, зарчмыг болон хоригдож байгаа этгээдтэй харьцах талаар НҮБ-аас тогтоосон хэм хэмжээг удирдлага болгоно.

3. Урьдчилан сэргийлэх дэд хороо нь нууцлалыг хадгалах, шудрага ёсыг эрхэмлэх, сонгож харьцахгүй байх, нийтлэг болон бодит байдлаар хандах зарчмыг мөн удирдлага болгоно.

4. Урьдчилан сэргийлэх хороо болон Оролцогч улсууд энэхүү протоколыг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллана.

### 3 дугаар зүйл

Оролцогч улс тус бүр үндэсний төвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх /цаашид "Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага" гэнэ/ зорилгоор хорих байгууллагад тогтмол очиж байх нэг буюу хэд хэдэн байгууллага байгуулах, томилох, эсхүл ийм байгууллагад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ.

### 4 дүгээр зүйл

1. Оролцогч улс тус бүр нь энэхүү протоколын дагуу 2, 3 дугаар зүйлд заасан тогтолцоонд өөрийн хэрэг шүүн таслах харьяалал, эсхүл хяналтад байгаа бөгөөд

төрийн байгууллага захиран тушааснаар, эсхүл зааснаар, эсхүл илд далд зөвшөөрснөөр хүн хоригдож байгаа /цаашид хоригдож байгаа газар гэнэ/ аливаа газар очих зөвшөөрөл олгоно. Ийнхүү очих нь дээрх хүмүүсийг эрүү шүүлт, бусад хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх зорилготой байна.

2. Энэ протоколд "хорих" гэдэгт бүх хэлбэрээр цагдан хорих болон шоронд хорих, эсхүл хувь хүнийг шүүхийн, захиргааны болон бусад эрх бүхий байгууллагын тушаалаар төрийн болон хувийн газар харуул хамгаалалтанд байлгах болон тухайн этгээд өөрийн хүсэлтээр түүнээс гарч явах боломжгүй байхыг хэлнэ.

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

Урьдчилан сэргийлэх дэд хороо

### 5 дугаар зүйл

1. Урьдчилан сэргийлэх дэд хороо 10 гишүүнтэй байна. Протоколыг соёрхон баталсан, эсхүл нэгдэн орсон 50 дахь бичиг баримтыг хадгалуулсаны дараа дэд хорооны гишүүдийн тоо 25 болно.

2. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүд ёс суртахууны өндөр төвшинтэй, шүүн таслах ажиллагааны дадлага туршлагатай, ялангуяа эрүүгийн хууль, хорих болон цагдаагийн байгууллагын, эсхүл хоригдож байгаа хүмүүстэй харьцдаг салбарт мэргэшсэн хүмүүс байна.

3. Урьдчилан сэргийлэх дэд хорооны бүтцэд оролцогч улсууд газар зүйн байршил, соёл иргэншлийн болон эрх зүйн тогтолцооны хувьд тэнцвэртэй төлөөллөөр хангагдах ёстой.

4. Энэ бүтцэд мөн жендерийн төлөөллийг эрх тэгш, үл ялгаварлан гадуурхах үндсэн дээр тэнцвэртэй хангах ёстой.

5. Урьдчилан сэргийлэх дэд хорооны бүрэлдэхүүнд нэг оролцогч улсыг төлөөлсөн 2 гишүүн байж болохгүй.

6. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүн нь хувь хүнийхээ хувьд хороонд ажиллах бөгөөд тэдгээр нь хараат бус, шудрагаар болон үр ашигтайгаар үүргээ гүйцэтгэнэ.

### 6 дугаар зүйл

1. Оролцогч улс тус бүр энэ зүйлийн 2 дахь заалтын дагуу Протоколын 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан болон зохих мэргэшлийн 2-оос илүүгүй нэр дэвшигчийн нэрийг дэвшүүлж, тэдгээрийн мэргэшлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлнэ.

2. а/ Нэр дэвшигч нь энэ протоколын оролцогч улсын харъяат байна.

б/ Хоёр нэр дэвшигчийн аль нэг нь нэр дэвшүүлж байгаа оролцогч улсын харъяат байна.

в/ Нэг оролцогч улсын 2-оос илүүгүй иргэний нэрийг дэвшүүлж болно.

г/ Аль нэг оролцогч улс өөр оролцогч улсын харьяатын нэрийг дэвшүүлсэн нөхцөлд тухайн улсын зөвшөөрлийг авсан байна.

3. Сонгууль явагдах хурал болохоос 5-аас доошгүй сарын өмнө НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга оролцогч улсуудад 3 сарын дотор дэд хорооны гишүүнд нэр дэвшүүлэхийг санал болгосон захидал илгээнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга нэр дэвшсэн хүмүүсийн нэрсийг цагаан толгойн дэс дарааллаар байрлуулж, нэр дэвшүүлсэн улсыг нь зааж хуралд оролцуулна.

## 7 дугаар зүйл

1. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүдийг дараах журмаар сонгоно:

а/ Энэхүү протоколын 5 дугаар зүйлийн шаардлага хангагдсан эсэхийг нэн тэргүүнд авч үзнэ.

б/ Анхны сонгуулийг энэхүү протокол хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дотор явуулна.

в/ Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүдийг оролцогч улсууд нууцаар санал хураах журмаар сонгоно.

г/ Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүдийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн 2 жил тутам зарлан хуралдуулдаг оролцогч улсуудын хурлаас сонгоно. Энэ хуралдаанд оролцогч улсуудын 2/3 оролцсон нөхцөлд хүчин төгөлдөр байна. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүнээр хамгийн өндөр санал авсан нэр дэвшигч сонгогдох бөгөөд хуралд оролцогчдын үнэмлэхүй олны санал авсан нэр дэвшигч сонгогдоно.

2. Сонгуулийн явцад нэг оролцогч улсын 2 харьяат нэгэн зэрэг Урьдчилан сэргийлэх дэд хороонд сонгогдох боломжтой болвол илүү олон тооны санал авсан нь Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүн болно. Хоёр нэр дэвшигч нь тэнцүү тооны санал авсан нөхцөлд дараах журам үйлчилнэ.

а/ Хоёр нэр дэвшигчийн аль нэгийх нь харьяалах оролцогч улс дэвшүүлсэн бол тухайн этгээд Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүн болно.

б/ Хоёр нэр дэвшигчийн хоёулангийн нэрийг харьяалах оролцогч улс дэвшүүлсэн бол нэр дэвшигч тус бүр дээр нууцаар санал хураана.

в/ Хоёр нэр дэвшигчийн нэгийх нь ч нэрийг харъяалах оролцогч улс дэвшүүлээгүй бол нэр дэвшигч тус бүр дээр нууцаар санал хураана.

#### 8 дугаар зүйл

Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүн нас барсан, огцорсон, эсхүл аливаа шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон бол тухайн гишүүний нэрийг дэвшүүлсэн оролцогч улс энэ хуулийн 5 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, зохих мэргэшилтэй, энэ албан тушаалд тохирох өөр хүний нэрийг дараагийн хурал хуралдах хүртэл хугацаагаар зохих эрх мэдлийн тэнцвэрийг хадгалах шаардлагыг харгалзан дийлэнхи оролцогч улсууд баталсан нөхцөлд ажиллуулахаар дэвшүүлнэ. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга нэр дэвшүүлсэн тухай мэдэгдсэнээс хойш 6 долоо хоногийн дотор оролцогч улсуудын тал болон түүнээс дээш хувь нь нэр дэвшигчийг эсэргүүцээгүй тохиолдолд нэр дэвшигчийг баталсанд тооцно.

#### 9 дүгээр зүйл

Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүнийг 4 жилийн хугацаагаар сонгоно. Тухайн этгээдийн нэрийг оролцогч улс дахин дэвшүүлсэн нөхцөлд дахин нэг удаа сонгогдох боломжтой. Анхны сонгуулиар сонгогдсон гишүүний тал хувийх нь сонгуулийн хугацаа 2 жил болсоны дараа дуусгавар болно. Эдгээр гишүүдийн нэрийг анхны сонгууль болсон даруйд энэхүү протоколын 7 дугаар зүйлийн 1-ний "г"-д заасан хуралдаан дээр хуралдааны дарга сугалаа сугалуулж сонгоно.

#### 10 дугаар зүйл

1. Урьдчилан сэргийлэх дэд хороо 2 жилийн хугацаагаар өөрийн албан тушаалтнуудыг сонгоно. Тэдгээрийг дахин сонгож болно.

2. Урьдчилан сэргийлэх дэд хороо өөрийн дүрэм, журмыг тогтооно. Үүнд тухайлбал дараах зүйлийг тусгана:

а/ Гишүүдийн тал хувь дээр нэмэх 1 гишүүн кворум бүрдүүлнэ.

б/ Урьдчилан сэргийлэх дэд хорооны шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар батлана.

в/ Урьдчилан сэргийлэх дэд хорооны хуралдаан хаалттай явагдана.

г/ Урьдчилан сэргийлэх дэд хорооны анхны хуралдааныг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга зарлан хуралдуулна. Анхны хуралдаанаас хойшхи хуралдааныг Урьдчилан сэргийлэх дэд хороо өөрийн дүрэм, журамд заасан хугацаанд явуулна. Урьдчилан сэргийлэх дэд хороо болон Эрүүдэн шүүхийн эсрэг хороо жилд нэгээс доошгүй удаа нэгэн зэрэг хуралдана.

## ГУРАВДУГААР ХЭСЭГ

Урьдчилан сэргийлэх дэд хорооны бүрэн эрх

11 дүгээр зүйл

Урьдчилан сэргийлэх дэд хороо дараах бүрэн эрхийг эдэлнэ:

а/ 4 дүгээр зүйлд заасан газруудад нэвтрэх, оролцогч улсуудад эрх чөлөөгөө хасуулсан этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцахаас хамгаалахтай холбоотой зөвлөмж өгөх,

б/ Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын хүрээнд:

I. Оролцогч улсуудад зөвлөгөө өгч, шаардлагатай бол ийм байгууллага байгуулахад нь тусалцаа үзүүлэх,

II. Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагатай шууд, шаардлагатай бол нууц холбоотой байж тэдгээрийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор сургалт явуулж, техникийн туслалцаа үзүүлэх,

III. Эрх чөлөөгөө хасуулсан этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцахаас хамгаалах явдлыг хүчтэй болгох хэрэгцээ болон аргаа тодорхойлоход нь зөвлөгөө өгч, тусламж үзүүлэх,

IV. Эрх чөлөөгөө хасуулсан этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцахаас хамгаалах үндэсний байгууллагын боломжийг нэмэгдүүлэх, бүрэн эрхийг бэхжүүлэх зөвлөмж, ажиглалтыг оролцогч улсуудад өгөх,

в/ Эрүүдэн шүүх явдлаас ерөнхийд нь урьдчилан сэргийлэх зорилгоор НҮБ-ын холбогдох байгууллага болон хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцахаас хамгаалах явдлыг бэхжүүлэх зорилготой олон улсын, бүс нутгийн болон үндэсний байгууллагуудтай хамтран ажиллана.

12 дугаар зүйл

Урьдчилан сэргийлэх дэд хороонд 11 зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж олгохын тулд оролцогч улсууд:

а/ Урьдчилан сэргийлэх дэд хороог өөрийн нутаг дэвсгэр дээр хүлээн авах болон энэхүү протоколын 4 дүгээр зүйлд заасан газарт нэвтрэх боломжийг олгоно.

б/ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцахаас хамгаалах явдлыг хүчтэй болгох зорилгоор авах арга хэмжээ болон хэрэгцээг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг Урьдчилан сэргийлэх дэд хороо шаардсан үед нь гаргаж өгнө.

в/ Урьдчилан сэргийлэх дэд хороо болон үндэсний байгууллагын хоорондын харилцааны уялдаа холбоог бэхжүүлж, түүнд дэмжлэг үзүүлнэ.

г/ Урьдчилан сэргийлэх дэд хорооны зөвлөмжийг судалж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хороотой хэлэлцэж байна.

### 13 дугаар зүйл

1. Урьдчилан сэргийлэх дэд хороо 11 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор оролцогч улсуудад очиж ажиллах хөтөлбөрөө хэрэгжүүлэх дарааллаа эхлээд сугалаагаар тогтооно.

2. Оролцогч улсууд дэд хорооны үзлэг хийхэд шаардагдах практик арга хэмжээг авах учраас Урьдчилан сэргийлэх дэд хороо зөвлөлдсөний дараа хугацаа алдалгүй оролцогч улсуудад өөрийн хөтөлбөрийн тухай мэдээлнэ.

3. Урьдчилан сэргийлэх хорооны 2-оос доошгүй гишүүн үзлэг хийх ажлыг гүйцэтгэнэ. Шаардлагатай бол эдгээр гишүүдийг энэ протоколд заасан салбарт мэргэжлийн туршлага, мэдлэгтэйгээ харуулсан шинжээч дагалдаж болно. Шинжээчийг оролцогч улсууд, ХЭДКГ, Олон улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын төвөөс өгсөн саналын дагуу гаргасан нэрсийн жагсаалтаас сонгоно. Энэ жагсаалтыг гаргахад оролцогч улс 5-аас илүүгүй тооны шинжээчийг татгалзаж болох бөгөөд Урьдчилан сэргийлэх дэд хороо өөр шинжээчдийг санал болгох ёстой.

4. Урьдчилан сэргийлэх хороо тогтмол үзлэг хийсний дараа шаардлагатай гэж үзвэл түр нэмэлт үзлэг хийж болно.

### 14 дүгээр зүйл

1. Дэд хороонд бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжийг олгох зорилгоор оролцогч улсууд дараахь үүргийг хүлээнэ:

а/ 4 дүгээр зүйлд заасан газарт байгаа хүмүүсийн талаар болон тэдгээрийн тоо, байршлын талаарх мэдээллийг ямар ч хязгаарлалтгүйгээр өгөх,

б/ тэдгээртэй харьцаж байгаа байдлын талаар болон тэдгээрийн хоригдож байгаа нөхцлийн талаарх мэдээллийг ямар ч хязгаарлалтгүйгээр өгөх,

в/ 2 дахь хэсэгт заасны дагуу хоригдож байгаа бүх газар, барилга, байшинд хязгаарлалтгүй нэвтрэх боломж олгох,

г/ гэрчгүйгээр хувиараа, эсхүл орчуулагчийн тусламжтайгаар эрх чөлөөгөө хасуулсан этгээдтэй, эсхүл Урьдчилан сэргийлэх дэд хорооны үзэж байгаагаар зохих мэдээлэл өгч болох аливаа этгээдтэй уулзах,

д/ Ямар нэгэн хязгаарлалтгүй очих газар, уулзах хүнээ сонгох

2. Тодорхой газарт очихыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, байгалийн гамшиг зэрэг гэнэтийн, эсхүл үндэслэл бүхий шалтгаанаар татгалзаж болно. Онцгой байдал зарласан нь ийм үзлэгээс татгалзах бие даасан үндэслэл болохгүй.

15 дугаар зүйл

Урьдчилан сэргийлэх дэд хороо, эсхүл түүний төлөөлөгчид мэдээлэл өгсөн хувь хүн, байгууллагад тэр мэдээлэл нь үнэн, худлыг эс харгалзан ямар ч эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийтгэл оногдуулах үүрэг өгөх, шийтгэл оногдуулах, эсхүл үүнийг зөвшөөрөх ёсгүй. Тухайн хувь хүн, байгууллагыг ямар нэгэн байдлаар хавчих ёсгүй.

16 дугаар зүйл

1. Урьдчилан сэргийлэх дэд хороо өөрийн зөвлөмж, ажиглалтыг оролцогч улсад, шаардлагатай бол үндэсний байгууллагад нууцаар илгээнэ.

2. Урьдчилан сэргийлэх дэд хороо хэрэв тухайн улсаас ийм хүсэлт гарсан бол өөрийн илтгэлийг оролцогч улсын тодруулгатай хамт нийтэлдэг. Оролцогч улс илтгэлийн зарим хэсгийг ил тод болговол Урьдчилан сэргийлэх дэд хороо илтгэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийтэлж болно. Гэхдээ хувь хүний мэдээллийг түүний шууд өгсөн зөвшөөрөлгүйгээр нийтлэх ёсгүй.

3. Урьдчилан сэргийлэх дэд хороо өөрийн жил тутмын ажлын тайланг Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд гаргаж өгнө.

4. Оролцогч улс 12,14 дүгээр зүйлийн дагуу Урьдчилан сэргийлэх дэд хороотой хамтран ажиллахаас татгалзах, эсхүл Урьдчилан сэргийлэх дэд хорооны зөвлөмжөөр байдлыг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээ авахаас татгалзаж байвал Эрүүдэн шүүхийн эсрэг хороо оролцогч улсын татгалзлын үндэслэлийг сонссоны дараа Урьдчилан сэргийлэх дэд хорооны хүсэлтээр энэ асуудлаар нийтэд зориулсан мэдэгдэл хийх, эсхүл дэд хорооны тайланг нийтлэх шийдвэр гаргаж болно.

**ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ**

Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага



## 17 дугаар зүйл

Энэхүү протокол хүчин төгөлдөр болсноос, эсхүл түүнийг соёрхон баталсанаас, эсхүл түүнд нэгдэж орсноос 1 жилээс илүүгүй хугацаанд оролцогч улс тус бүр нь үндэсний төвшинд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэг болон түүнээс илүү тооны байгууллагад дэмжлэг үзүүлж, томилж, байгуулж болно. Төвийн биш байгууллагаас байгуулсан урьдчилан сэргийлэх байгууллага нь энэхүү Протоколын шаардлагыг хангаж байвал Үндэсний байгууллагаар томилогдож болно.

## 18 дугаар зүйл

1. Оролцогч улс үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага, түүний ажилтан чиг үүргийнхээ хувьд хараат бус байх явдлыг хангана.

2. Оролцогч улс орнууд үндэсний байгууллагын шинжээчид шаардагдах ур чадвар, мэдлэг эзэмшсэн байх явдлыг хангах арга хэмжээ авна. Мөн жендерийн, угсаатны болон цөөнхийн бүлэг энэ байгууллагад тэнцүү төлөөлөлтэй байх явдлыг хангана.

3. Оролцогч улсууд үндэсний байгууллага чиг үүргээ биелүүлэхэд нь шаардагдах нөөцөөр хангах үүрэг хүлээнэ.

4. Үндэсний байгууллагыг бий болгохдоо оролцогч улс хүний эрхийг хамгаалах, дэмжих үндэсний байгууллагын статус болон үйл ажиллагааны зарчмыг харгалзаж үзнэ.

## 19 дүгээр зүйл

Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагад наад заах нь дараахь бүрэн эрхийг олгоно.

а/ 4 дүгээр зүйлд заасан газарт байгаа эрх чөлөөгөө хасуулсан этгээдтэй харьцаж байгаа байдлыг түүнийг эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцахаас хамгаалах байгууллагыг байгуулах зорилгоор тогтмол хянах,

б/ эрх чөлөөгөө хасуулсан этгээдтэй харьцах болон түүний байгаа нөхцлийг сайжруулах болон эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцах явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор НҮБ-ын зохих хэм хэмжээг харгалзан холбогдох байгууллагад зөвлөмж явуулах,

в/ Мөрдөж байгаа болон төслийн хэлбэрээр байгаа хуулийн талаар саналаа дэвшүүлэх.

## 20 дугаар зүйл

Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагаас өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх явдлыг хангах үүднээс оролцогч улс дараахь үүргийг хүлээнэ:

а/ 4 дүгээр зүйлд заасан газарт байгаа эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн тоо, ийм газрын тоо, тэдгээрийн байршлын талаар ямар ч хязгаарлалтгүйгээр мэдээлэл өгөх,

б/ тэдгээр хүмүүстэй харьцаж байгаа байдлын талаар болон тэдгээрийн хоригдож байгаа нөхцлийн талаар ямар ч хязгаарлалтгүйгээр мэдээлэл өгөх,

в/ 2 дахь хэсэгт заасны дагуу хоригдож байгаа бүх газар, барилга, байшинд хязгаарлалтгүйгээр нэвтрэх,

г/ гэрчгүйгээр хувиараа, эсхүл орчуулагчийн тусламжтайгаар эрх чөлөөгөө хасуулсан этгээдтэй, эсхүл Урьдчилан сэргийлэх байгууллагын үзэж байгаагаар холбогдох мэдээлэл өгч болох аливаа этгээдтэй уулзах,

д/ Ямар нэгэн хязгаарлалтгүйгээр очих газар, уулзах хүнээ сонгох,

е/ Урьдчилан сэргийлэх хорооны мэдээлэл илгээх, эсхүл тэдгээрийн хүмүүстэй уулзах эрхтэй байх явдлыг хангана.

#### 21 дүгээр зүйл

1. Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагад мэдээлэл өгсөн хувь хүн, байгууллагад тэр мэдээлэл нь үнэн, худлыг эс харгалзан ямар ч эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийтгэл оногдуулах үүрэг өгөх, шийтгэл оногдуулах, эсхүл үүнийг зөвшөөрөх ёсгүй. Тухайн хувь хүн, байгууллагыг ямар нэгэн байдлаар хавчих ёсгүй.

2. Үндэсний урьдчилсан сэргийлэх байгууллагын цуглуулсан нууц мэдээллийг ил тод болгох ёсгүй. Хувь хүний тухай мэдээллийг зөвхөн холбогдох этгээдийн бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн нийтэлж болно.

#### 22 дүгээр зүйл

Холбогдох оролцогч улсын эрх бүхий байгууллага үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын зөвлөмжийг судалж, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар түүнтэй хэлэлцүүлэг өрнүүлнэ.

#### 23 дугаар зүйл

Энэхүү протоколын оролцогч улс үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын жил бүрийн тайлан илтгэлийг хэвлэн нийтлэх, нийтийн хүртээл болгох үүрэг хүлээнэ.

## ТАВДУГААР ХЭСЭГ

Мэдэгдэл

24 дүгээр зүйл

1. Оролцогч улс энэхүү протоколыг соёрхон батлахдаа 3,4 дүгээр хэсгийг хэрэгжүүлэхээ тодорхой хугацаагаар хойшлуулах тухай мэдэгдэл хийж болно.

2. Хойшлуулах энэхүү мэдэгдэл нь хамгийн дээд тал нь 3 жилийн хугацаанд хүчинтэй байна. Оролцогч улс зохих материалыг бүрдүүлж өгснөөр Эрүүдэн шүүхийн эсрэг хороо Урьдчилан сэргийлэх дэд хороотой зөвшилцөж энэ хугацааг дахин 2 жилийн хугацаагаар сунгаж болно.

## ЗУРГАДУГААР ХЭСЭГ

Санхүүгийн холбогдолтой заалт

25 дугаар зүйл

1. Энэхүү протоколыг хэрэгжүүлэх явцад Урьдчилан сэргийлэх дэд хорооноос гаргасан зардлыг НҮБ хариуцна.

2. Энэхүү протоколын дагуу Урьдчилан сэргийлэх дэд хороонд үүргээ зохистой биелүүлэхэд шаардагдах хүн хүчний болон бусад нөөцөөр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болон НҮБ хангана.

26 дугаар зүйл

1. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн зохих журмын дагуу Тусгай санг байгуулна. Энэ санг НҮБ-ын дүрэм, журмын дагуу захиран зарцуулж, Урьдчилан сэргийлэх дэд хороо тухайн оронд очсоны дараа гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх, үндэсний байгууллагыг дэмжих, сургалтын хөтөлбөрт санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зарцуулна.

2. Тусгай Санг Засгийн газар, засгийн газар хоорондын байгууллага, төрийн бус байгууллага, хувийн болон төрийн байгууллагын сайн дурын хандиваар санхүүжүүлж болно.

## ДОЛДУГААР ХЭСЭГ

Төгсгөлийн заалт

1. Энэхүү протокол нь конвенцийг баталсан аль ч улсын хувьд гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Энэхүү протоколыг конвенцийг соёрхон баталсан, эсхүл түүнд нэгдэж орсон аль ч улс соёрхон батлана. Соёрхон баталсан тухай баримт бичгийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар өгнө.

3. Энэхүү протокол нь конвенцийг соёрхон баталсан, эсхүл түүнд нэгдэж орсон аль ч улсын хувьд нэгдэж ороход нээлттэй байна.

4. Нэгдэж орох нь нэгдэж орсон тухай баримт бичгийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар гардуулсанаар хэрэгжинэ.

5. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү протоколд гарын үсэг зурсан, эсхүл нэгдэж орсон бүх улсуудад соёрхон батлах, эсхүл нэгдэж орох тухай баримтыг хадгалуулахаар өгсөн тохиолдол тус бүрийн тухай мэдээлнэ.

28 дугаар зүйл

1. Энэхүү протокол нь соёрхон баталсан, эсхүл нэгдэж орсон тухай 20 дахь баримт бичгийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш 30 дахь өдөр хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү протоколыг соёрхон баталсан, эсхүл нэгдэж орсон тухай 20 дахь баримт бичгийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш Протоколыг соёрхон баталсан, эсхүл нэгдэж орсон оролцогч улсын тухайд өөрийн соёрхон баталсан, эсхүл нэгдэж орсон тухай баримт бичгийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш 30 дахь өдөрт Протокол хүчин төгөлдөр болно.

29 дүгээр зүйл

Энэхүү протоколын заалт нь Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг бүх хэсэгт ямар нэгэн хязгаарлалт, онцлон үзэх тохиолдолгүй үйлчилнэ.

30 дугаар зүйл

Энэхүү протоколд нэгдэж ороход ямар нэгэн тайлбар хийхгүй.

31 дүгээр зүйл

Энэхүү протоколын заалт нь хорих байгууллагад тогтмол үзлэг хийх бүсийн бусад гэрээний үүрэгт ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй. Урьдчилан сэргийлэх дэд хороо болон бүсийн конвенцийн дагуу байгуулагдсан байгууллага давхардлыг арилгах, энэ протоколын зорилгыг биелүүлэх үүднээс зөвшилцөх, хамтран ажиллах үүргийг хүлээнэ.

### 32 дугаар зүйл

Энэхүү протоколын заалт нь оролцогч улсын 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн 4 конвенц, тэдгээрийн 1977 оны 6 дугаар сарын 8-ны нэмэлт протокол, олон улсын хүмүүнлэгийн хуульд хамаарахгүй тохиолдолд хорих газарт очих эрхийг Улаан загалмайн нийгэмлэгийн Олон Улсын хороонд олгох үүрэгт нөлөөлөхгүй.

### 33 дугаар зүйл

1. Оролцогч улс энэхүү протоколыг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдсэний үндсэн дээр аль ч үед цуцалж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга энэ тухай энэхүү протоколын болон конвенцийн оролцогч улсуудад мэдэгдэнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүлээн авсанаас хойш 1 жилийн дараа протоколыг цуцалсанд тооцно.

2. Ийнхүү цуцалсан нь оролцогч улсыг протоколыг цуцлахаас өмнө үүссэн нөхцөл байдлын дагуу хүлээсэн үүргээ болон Урьдчилан сэргийлэх дэд хорооноос өгсөн, эсхүл өгч болох үүргийг биелүүлэхээс чөлөөлөхөд нөлөөлөхгүй. Протоколыг цуцлах нь Урьдчилан сэргийлэх дэд хорооноос түүнийг цуцлахаас өмнө авч хэлэлцэж байсан ямар ч асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэхэд саад болохгүй.

3. Оролцогч улсын цуцалсан шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш Урьдчилан сэргийлэх дэд хороо тухайн оролцогч улстай холбоотой ямар ч асуудлыг шинээр авч үзэхгүй.

### 34 дүгээр зүйл

1. Энэхүү Протоколд оролцогч аливаа улс засвар оруулах санал гаргаж, энэ тухайгаа НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга санал болгосон аливаа засварыг энэхүү протоколд оролцогч улсуудад хүргүүлж, түүнийг хэлэлцэж санал хураах зорилгоор Протоколд оролцогч улсуудын Бага хурал хуралдуулах саналтай эсэхийг мэдэгдэхийг хүснэ. Хэрэв оролцогч улсуудын 1/3 доошгүй нь Бага хурал хуралдуулах саналтай байвал НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга НҮБ-ын ивээл дор Бага хурлыг хуралдуулна. Энэхүү Бага хуралд оролцсон хийгээд саналаа өгсөн оролцогч улсыг олонхи дэмжсэн аливаа засварыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейд батлуулахаар оруулна.

2. Эдгээр засвар нь НҮБ-ын Ерөнхий Ассамблей баталж, энэхүү Пактад оролцогч улсуудын 2/3 үндсэн хуулийнхаа горим, журмын дагуу тэдгээрийг баталмагц хүчин тегөлдөр болно.

3. Хүчин төгөлдөр болсон засвар нь түүнийг баталсан оролцогч улсуудын хувьд заавал дагаж мөрдөх зүйл болно. Харин бусад оролцогч улсуудын хувьд энэхүү Протоколын заалт болон тэдгээр улсаас урьд өмнө баталсан аливаа засвар заавал дагаж мөрдөх хүчинтэй хэвээр байна.

### 35 дугаар зүйл

Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүн, үндэсний урьдчилан сэргийлэх хорооны гишүүн өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах дархан эрх, эрх ямба эдлэнэ. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүд 1946 оны 2 дугаар сарын 13-нд баталсан НҮБ-ын дархан эрх, эрх ямбын тухай конвенцийн 22 дугаар зүйлд заасан дархан эрх, эрх ямбыг мөн конвенцийн 23 зүйлд заасан нөхцөлийг хангасны үндсэн дээр эдлэнэ.

### 36 дугаар зүйл

Оролцогч улсад очихдоо Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүд энэхүү Протоколын заалт, зорилго болон өөрийн дархан эрх, эрх ямбад хохиролгүйгээр:

а/ очсон орны хууль болон хэм хэмжээг сахина,

б/ өөрийн олон улсын үүргийг шудрагаар хэрэгжүүлэхэд нийцэхгүй үйлдэл, үйл ажиллагаанд оролцохоос татгалзана.

### 37 дугаар зүйл

1. Энэхүү Протоколын араб, хятад, англи, франц, орос болон испани эх бичвэр нь адил хүчинтэй бөгөөд түүнийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Протоколын баталгаатай хувийг бүх улсуудад хүргүүлнэ.

*Жич: Энэхүү нэмэлт Протоколд Монгол Улс нэгдэн орох тухай асуудал хэлэлцүүлгийн шатанд явж байгаа болно. 2011 оны дөрөвдүгээр сарын 28.*